

”ДБЭХС“ ТӨХК

**ЗУУХ№5-ЫН УТАА СОРОГЧИЙН ЗАСВАРЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭГЧИЙГ
СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Тендер
шалгаруулалт/
гэрээний нэр, дугаар: **“Зуух№5-ын утаа сорогчийн засварын ажил**
ДБЭХС/202001034

Дорнод аймаг

2020 он

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2020.03.25

Тендер шалгаруулалтын нэр: Зуух №5 ын утас сорогчийн засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын тендер

Тендер шалгаруулалтын дугаар: ДБЭХС/202001034

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК эрх бүхий тендерт оролцогчдоос “Зуух №5-ын утас сорогчийн засварын” ажлыг гүйцэтгэх тухай цахим үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг www.tender.gov.mn хаягаар орж авах ба эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр 100,000.0 (Зуун мянга) төгрөг төлснөөр тендер шалгаруулалтанд оролцож болно.

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: **Шаардлагатай**.

Тендерийг 2020 оны 04 дугаар сарын 07 ны өдрийн 14 цаг 00 минутаас өмнө Худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэрээр ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2020 оны 04 дугаар сарын 07 ны өдрийн 14 цаг 20 минутанд нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй
Дотоодын давуу эрх тооцохгүй

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Дорнод аймаг, Хэрлэн сум, 1 дүгээр баг
“Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн төв байр
Утас: 99109027, 99041613
Факс: 70584545

Хоёр ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
 - 2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тендерийн үнэ**
 - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
 - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
 - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
 - 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
- 5. Үнийн**
 - 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30хоногийн

**саналын
хүчинтэй
байх хугацаа**

хугацаанд хүчинтэй байна.

**6. Алдааг
залруулах**

- 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
 - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
 - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үргүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.

- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцгчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.

**7. Санал
болгосон
үнэ, түүнийг
үнэлэх**

- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

**8. Гэрээ
байгуулах
эрх олгох
тухай
мэдэгдэл**

- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав.**ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

| ТОӨЗ-НЫХОЛБОГОДОХЗААЛТ | Шалгуур үзүүлэлт |
|------------------------|---|
| ТОӨЗ 1.1 | <p>Сүүлийн [2018, 2019] жилийн санхүүгийн тайлан аудитаар баталгаажуулсан байх./</p> <p>Тендерт оролцогч дараах нэмэлт материалуудыг өөрийн тендерт ирүүлнэ.Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. 03.3.3 категори кодтой тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар 2. Зураг, ажлын тоо хэмжээний дагуу тооцсон төсөвтэй, эрх бүхий төсөвчнөөр баталгаажуулсан байна. 3. Ажил гүйцэтгэх нарийвчилсан хугацааны хувваарийг баталгаажуулан ирүүлнэ. 4. Төсөвт магадлашгүй ажлын зардал 967,908.0 төгрөгийг тусгаж ирүүлэх 5. Төсөвт захиалагчийн техник хяналтын зардал 483,954.0 төгрөгийг тусгаж ирүүлэх 6. Төсөвт стандарт нормчлолын сангийн 86,905.0 төгрөгийг тусгаж ирүүлэх <p>Тендерийн баталгааны үнийн дүн:</p> <ol style="list-style-type: none"> 7. 996945.0 (Есөн зуун ерэн зургаан мянга есөн зуун дөчин таван төгрөг) <p>ТШӨХ-д шаардсан материалуудын аль нэгийг ирүүлээгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.</p> <p>Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил</p> <p>Сүүлийн 2 жилийн аль нэг жилд тендерт оролцогч нь зуухны угсралт, засварын ажил хийж байсан туршлагатай байна.</p> <p>Уг ажлын гэрээ, ажил хүлээлгэж өгсөн улсын комиссын акт, захиалагчийн тодорхойлолтыг хавсаргана.</p> <p>Ижил төстэй ажилд зөвхөн Эрчим хүчний яамны олгодог 03.3.3 заалтуудын хүрээнд хийгдсэн ажлуудыг тооцино.</p> <p>Уг ажлын гэрээ, ажил хүлээлгэж өгсөн улсын комиссын акт, захиалагчийн тодорхойлолтыг хавсаргана.</p> <p>Уг ажлыг гүйцэтгэхэд тусгай зөвшөөрөл зайлшгүй шаардлагатай эсэх: “Шаардлагатай”</p> <p style="text-align: center;">03.3.3.350-450°C-ээс дээшигтепературтай, 40-80 кгх/см2-аас дээши даралттай зуухны угсралт, засвар, түүний туришилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ</p> <p>Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний эхээс хийсэн хуулбарыг нотариатаар баталгаажуулан ирүүлнэ.</p> <p>Түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгчид нь гүйцэтгэх ажил үүргийнхээ дагуу тусгай зөвшөөрөлтэй байна</p> |

| | <p>Борлуулалтын хэмжээ: 2018, 2019 оны борлуулалт</p> <p>Борлуулалтын орлого: 50,000,000.0 төгрөгөөс багагүй байх Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн: 50,000,000.0 төгрөгөөс багагүй.</p> <ul style="list-style-type: none"> ◆ Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмжийн жагсаалтыг МАЯГТ №ТШМ-6-д заасны дагуу бөглөж ирүүлнэ. Түрээсээр ашиглах бол гэрчилгээний хуулбарыг нотариатаар батлуулж, түрээсийн гэрээг хавсаргаж, түрээслүүлэгчийнх мөн болохийг тодорхойлох баримтыг ирүүлэх. <p>Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмжийн жагсаалтыг МАЯГТ №ТШМ-6-д заасны дагуу бөглөж ирүүлнэ. Түрээсээр ашиглах бол гэрчилгээний хуулбарыг нотариатаар батлуулж, түрээсийн гэрээг хавсаргаж, түрээслүүлэгчийнх мөн болохийг тодорхойлох баримтыг ирүүлэх.</p> <p>Мөн дээрх тоног төхөөрөмжүүдийг фото зургаар баталгаажуулан ирүүлнэ.</p> <ul style="list-style-type: none"> ◆ “ДБЭХС” ТӨХК-ийн тельфер, хөдөлмөр хамгаалалын өрөө, бэлтгэх хэсэг зэргийг түрээслэх бол түрээслэх тухай саналаа ирүүлэх <p>Ерөнхий инженер нь гэрээнд заасан ажилтай төрөл, үнийн дүнгээрээ дүйцэх ажил дээр ажилласан туршлагатай байх хугацаа: 2 жил</p> <p>Түүний дотроос гэрээг хариуцаж ажилласан туршлагатай байх хугацаа: 2 жил</p> <ul style="list-style-type: none"> ◆ Мөн инженер техникийн ажилтнууд болон гагнуурчид нь заавал тухайн байгууллагын үндсэн ажилтнууд байх байндлын даатгалын хэлтсээс олгодог баталгаажуулсан НД-8 маягтыг сүүлийн 5 сарын байдлаар хавсарган ирүүлнэ. (НД-8 маягтаас тухайн байгууллагын үндсэн ажилтан мөн эсэхийг хянан үзнэ.) <p>Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн аюулгүй ажиллагааны ажилтныг захирлын тушаалаар томилсон байх ба тус ажилтан нь мэргэжлийн сертификаттай байна.</p> <p>Дараах хүснэгтэд үзүүлсэн удирдах болон инженер техникийн ажилтныг ажиллуулна. Үндсэн 3 инженер нь:</p> <table border="1"> <thead> <tr> <th>Албан тушаал</th><th>Хүний тоо</th><th>Ажлын туршлага (жил)</th></tr> </thead> <tbody> <tr> <td>Ерөнхий инженер(дулааны инженер)</td><td>1</td><td>3 буюу түүнээс дээш</td></tr> <tr> <td>Засварын инженер(дулааны инженер)</td><td>1</td><td>3 буюу түүнээс дээш</td></tr> <tr> <td>Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны ажилтан</td><td>1</td><td>2 буюу түүнээс дээш</td></tr> <tr> <td>ИТА нарын диплом, нийгмийн даатгалын дэвтрийн хуулбарыг</td><td></td><td></td></tr> </tbody> </table> | Албан тушаал | Хүний тоо | Ажлын туршлага (жил) | Ерөнхий инженер(дулааны инженер) | 1 | 3 буюу түүнээс дээш | Засварын инженер(дулааны инженер) | 1 | 3 буюу түүнээс дээш | Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны ажилтан | 1 | 2 буюу түүнээс дээш | ИТА нарын диплом, нийгмийн даатгалын дэвтрийн хуулбарыг | | |
|---|---|----------------------|-----------|----------------------|----------------------------------|---|---------------------|-----------------------------------|---|---------------------|--|---|---------------------|---|--|--|
| Албан тушаал | Хүний тоо | Ажлын туршлага (жил) | | | | | | | | | | | | | | |
| Ерөнхий инженер(дулааны инженер) | 1 | 3 буюу түүнээс дээш | | | | | | | | | | | | | | |
| Засварын инженер(дулааны инженер) | 1 | 3 буюу түүнээс дээш | | | | | | | | | | | | | | |
| Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны ажилтан | 1 | 2 буюу түүнээс дээш | | | | | | | | | | | | | | |
| ИТА нарын диплом, нийгмийн даатгалын дэвтрийн хуулбарыг | | | | | | | | | | | | | | | | |

| | хавсарган ирүүлэх. | | | |
|---|-----------------------|----------------------|--|--|
| Албан тушаал | Хүний тоо | Ажлын туршлага (жил) | Зэрэг категори | |
| Гагнуурчин (цахилгаан) | Тус бүр 2 оос багагүй | 3 аас багагүй | Эрчим хүчний салбарт мөрдөгддөг II ¹ категориос багагүй | |
| Огтлогч | Нэгээс багагүй | 3 аас багагүй | Мэргэжлийн үнэмлэхтэй байна. | |
| Категорын шаардлага хангасан гагнуурчдын мэргэжлийн(категорын) үнэмлэхийн хугацаа дуусаагүй байх бацуулбарыг хавсаргах. | | | | |

| | |
|-----------------|--|
| ТОӨЗ 2.1 | <p>Захиалагчаас тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга авах хаяг:</p> <p><i>Тендерт оролцогчид тодоруулга хүссэн тохиолдолд бичгээр ирүүлэх ба хариуг доорхи худалдан авах ажиллагааны цахим хаяг www.tender.gov.mn –д дээр тавих тул тендерт оролцогч нар шалгаж байх шаардлагатай тул анхаарна уу?</i></p> <p>Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлт хүлээн авах хугацаа ажлын 5 хоногоос багагүй байна. Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: 2020 оны 04 дугаар сарын 07-ны өдөр</p> <p>Цаг: 14 цаг 00 минут</p> |
| ТОӨЗ 2.1 | <p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Тендер хүлээн авахэцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: 2020 оны 04 дугаар сарын 07-ны өдөр</p> <p>Цаг: 14 цаг 20 минут</p> |
| ТОӨЗ 2.3 | <p>Долдугаар бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. <i>[Тендерт оролцогчийг эрх бүхий болохыг нотлохтой холбоотойгоор ТШӨХ-д заасан бүх баримт бичгийгжагсаан бичих]</i> 2. ... 3. |
| ТОӨЗ 6.2 | <p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <i>[Зуух №5 ын утгаа сорогчийн засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын тендер] ДБЭХС/202001034</i></p> |

Дөрөв. **ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР



Ө.ЖАРГАЛСАЙХАН

ДС-5 ҮН АЖЛЫН ДУГУЙ СОЛИХ
ЗАСВАРЫН АЖЛЫН ЭЗЭЛХҮҮН

2019.11.20

Хэрлэн сум

| д/д | Хийгдэх ажилбарын нэрс | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Тайлбар |
|-----|--|-------------|------------|---------|
| 1 | Багерийн аж ахуйн тельферийг шалгах, турших | ком | 1 | |
| 2 | ДС-5 үн изоляци хуулах | м2 | 20 | |
| 3 | ДС-5 үн дээд талын крышка салгаж авах | ком | 1 | |
| 4 | ДС-5-ын хөдөлгүүрийг авах | ш | 1 | |
| 5 | Муфтнуудыг сугалах | ш | 2 | |
| 6 | Холхивчуудыг сугалах | ш | 2 | |
| 7 | Ажлын дугуйг голтой өргөж гаргах | ком | 1 | |
| 8 | Ажлын дугуйг салгах авах | ш | 1 | |
| 9 | Голд хэмжилт хийх | ком | 1 | |
| 10 | Шинээр тавих ажлын дугуйнд хэмжилт хийх | ком | 1 | |
| 11 | Ажлын дугуй суулгах | ком | 1 | |
| 12 | Корпусны дотор хуяг демантожлаж авах | м2 | 20 | |
| 13 | б=8 лист хэмжээ тавих, зүсэх, дотор хуяг хийж бэхлэх | м2 | 20 | |
| 14 | Ажлын дугуйг голтой нь байрлуулах | ком | 1 | |
| 15 | Холхивчууд суулгах | ш | 2 | |
| 16 | Дээд талын крышка тавих | ш | 1 | |
| 17 | Диффузерийн листүүдийг солих | к | 2 | |
| 18 | Муфтнуудыг суулгах | ш | 2 | |
| 19 | Хөдөлгүүр тавих | ш | 1 | |
| 20 | Гадна изоляцуудыг хийж будах | м2 | 20 | |
| 21 | Ажлын дугуйнд баланс хийж тааруулах | ком | 1 | |
| 22 | Муфт холбож, центровки хийх, ДС-ийг явуулж доргио хэмжих | ком | 1 | |
| 23 | Люкнуудын боолтуудыг солих | ш | 3 | |

ХЯНАСАН

ИА-НЫ ДАРГА

Б.БЯМБАА

ЗТХ-ИЙН ИНЖЕНЕР

Б.БАТ

АЖЛЫН ЭЗЭЛХҮҮН ГАРГАСАН:

ЗУУХАН ЦЕХИЙН ДАРГА

С.ГАНБААТАР

**ДС-5 ҮН АЖЛЫН ДУГУЙ СОЛИХОД ШААРДЛАГАТАЙ
МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ**

2020.02.03

| д/д | Материалын нэр | Тип марк | Хэмжих нэгж | Тоо хэмжээ |
|-----|-----------------|----------|-------------|------------|
| 1 | Лист | б=8 | тонн | 3 |
| 2 | Лист | б=2 | тонн | 0.4 |
| 3 | Нунтаг азбест | | тонн | 1 |
| 4 | Шилэн хөвөн | | рулон | 10 |
| 5 | Изоляцны тор | | рулон | 15 |
| 6 | Барилгын цемент | | тонн | 1 |
| 7 | Хошуувч | | ш | 30 |
| 8 | Нүдний шил | | ш | 4 |
| 9 | Бээлий | | ш | 20 |
| 10 | Электрод | J-506 | кг | 70 |
| 11 | Будаг | цэнхэр | кг | 45 |
| 12 | Кислород | | м3 | 36 |
| 13 | Карбид | | кг | 50 |
| 14 | Өнгөлөгч чулуу | Ф16 | ш | 40 |
| 15 | Арчих материал | | метр | 50 |
| 16 | Холхивч | 3636 | ш | 2 |

Тав. ЗУРАГ

Зургийн санамж

Энд зургуудыг жагсааж бичнэ. Зураг, түүний дотор ажлын талбайн зурийг энэ бүлэгт, эсхүл тусад нь хавтсанд хийж хавсаргана.

Зургаа. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

Үе шатны ажлын хуваарь бэлтгэх санамж

Зорилт

Үе шатны ажлын хуваарийг дараах зорилгоор бэлтгэдэг. Үүнд:

- гэрээний дагуу гүйцэтгэх ажлын тоо хэмжээний талаар хангалттай мэдээллийг гаргаж тендерийг зохих ёсоор, нягт нямбай бэлтгэх бололцоог олгох;
- (б) гэрээ байгуулсны дараа ажлын гүйцэтгэлийг тооцож үнэлэхэд үе шатны ажлын хуваарыг заасан үнийг үндэслэх.

Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхийн тулд үе шатны ажлын хуваарыг хоорондоо ялгаатай ажлуудын, эсхүл өөр өөр газар гүйцэтгэх ижил төстэй ажлын ялгааг гаргаж өгөх, эсхүл өртгийг ялгаатайгаар авч үзэх нөхцөлийг харгалзах зорилгоор үе шатны ажлын хуваарийг зохих нэр төрлөөр нь задлах хэрэгтэй. Эдгээр шаардлагатай нийцүүлэн үе шатны ажлын хуваарийн агуулга аль болохоор энгийн бөгөөд товч байх ёстой. Гадна тохижилтын ажил болон нөхөн сэргээх зардлыг үе шатны ажлын хуваарыг заавал оруулна.

Ажил-өдрийн хуваарь

Ажил-өдрийн хуваарийг үе шатны ажлын хуваарийн нэр төрөлд тусгагдаагүй магадлашгүй ажил гарах магадлал өндөр бол оруулна. Тендерт оролцогчийн ирүүлсэн нэгж үнэ бодитой эсэхийг шалгах боломжийг захиалагчид олгох зорилгоор ажил-өдрийн хуваарыг нь ихэвчлэн дараах зүйлээс бүрдэнэ:

- тендерт оролцогч ажил-өдрийн нийт үнийг бөглөж ирүүлэх ажиллах хүч, материал, барилга байгууламжийн нэр төрлийн жагсаалт. Мөн ажил-өдрийн хэлбэрээр гүйцэтгэсэн ажилд төлбөр хийх нөхцөлийн талаарх мэдээлэл.
- (б) тендерт оролцогч бүрийн нэгж үнээр үнэлж ирүүлэх ажил-өдрийн нэр төрлийн тоо хэмжээ. Тендерт оролцогчийн ажил-өдрийн нэр төрөлд санал болгох нэгж үнэ нь гүйцэтгэгчийн ашиг, захиргааны, хяналтын болон бусад зардлыг багтаасан байна.

Магадлашгүй зардал

Магадлашгүй ажлын зардалд зориулсан тодорхой мөнгөн дүнг үе шатны ажлын хуваарыг заах замаар магадлашгүй ажлын зардлын талаар ерөнхий заалт оруулж болно. Мөн үнийн өсөлтөд зориулсан тодорхой дүнг магадлашгүй зардал хэлбэрээр үе шатны ажлын хуваарыг зааж болно. Магадлашгүй зардлыг гэрээнд тусгах нь ирээдүйд шаардлага гарсан үед нэмэлт төсөв хуваарилуулж батлуулах ажиллагаанаас зайлсхийх бололцоо олгоно. Магадлашгүй зардлыг хэрэглэсэн үед гэрээний тусгай нөхцөлд тэдгээрийг хэний зөвшөөрлөөр (ихэвчлэн төслийн менежерийн) хэрхэн хэрэглэх аргыг заана.

Үе шатны ажлын хуваарь бэлтгэхэд зориулсан энэ санамж нь зөвхөн захиалагч болон тендерийн баримт бичгийг боловсруулж буй хүмүүст зориулагдсан болно. Эдгээрийг эцсийн баримт бичигт оруулахгүй.

Долоо.ЖИШИГ МАЯГТ
ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
5. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгднө.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| 1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ. |
| 2. Төслийн менежерийн шийдвэр | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ. |
| 3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана. |
| 4. Аюулгүй байдал | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана. 4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гол түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ. |
| 5. Зааварчилгаа | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй |
| 6. Маргааныг шийдвэрлэх | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ

- | | |
|-------------------------------------|---|
| 7. Ажлын хөтөлбөр | 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхдэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна. |
| 8. Зөрчил, гологдол илрүүлэх | 7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| 9. Зөрчил, гологдол арилгах | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй. |
| | 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа ¹ дуусхаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана. |
| | 9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд |

¹ Чанарынбаталгаатхугацаагтогоохдоо Иргэнийхууль болон Барилгынтухайхуулийг баримтална.

| | | |
|---|-------|--|
| | | заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана. |
| 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх | 10.1. | Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна. |
| В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ | | |
| 11. Үе шатны ажлын хуваарь | 11.1. | Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарь тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна. |
| 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх | 11.2. | Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ. |
| 13. Алданги | 12.1. | Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарь нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй. |
| | 13.1. | Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги ² төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс сүүтган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. |
| Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ | | |
| 14. Ажил дуусгах | 14.1. | Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлцуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна. |
| 15. Хүлээж авах | 15.1. | Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна. |
| 16. Эцсийн тооцоо | 16.1. | Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусгахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай запруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана. |
| 17. Ашиглалт, | 17.1. | Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, |

² Алдангийгихэвчлэнхоногт 0.05-0.10 хувиартогтоохбөгөөднийтдуннъгэрээнийүнийн 5-10%-иасхэтрэхёсгүй.

| | |
|---|--|
| засвар, үйлчилгээни й гарын авлага | <p>инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.</p> |
| | <p>17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.</p> |
| 18. Гэрээг цуцлах | <p>18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.</p> <p>18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгэрээр хязгаарлагдахгүй:</p> <ul style="list-style-type: none"> (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон; (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй; (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан; (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй; (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон. <p>18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.</p> |
| 19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр | <p>19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.</p> <p>19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.</p> |
| 20. Гүйцэтгэлээс чөлөөлөх | <p>20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа</p> |

ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсоон. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийт гүйцэтгэгчид төлнө.

Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ³

| | |
|-----------------|---|
| ГЕН 2.1 | Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: <i>[Зуух №5 ын утаа сорогчийн засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын тендер, ДБЭХС/202001034]</i> |
| ГЕН 2.1 | Ажил нь <i>[Зуух №5 ын утаа сорогчийн засварын ажил]</i> -аас бүрдэнэ. Ажлын талбай нь <i>[“ДБЭХС”ТӨХК-ийн Дорнод аймаг дахь үйлдвэрийн блок]</i> -д байрших ба зураг №...-д зааснаар тодорхойлогдсон болно. |
| ГЕН 3.1 | Төслийн менежер нь <i>Г.Отгонбаатар</i> |
| ГЕН 4.1 | Ажил эхлэх өдөр <i>[2020 оны 08 дугаар сарын 01 ний өдөр.</i> <i>(Жич: “ДБЭХС”ТӨХК-ийн горим ажиллагаанаас хамаарч хугацаа өөрчлөгдөж болно.)</i> |
| | Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр <i>[2020 оны 08 дугаар сарын 30 ний өдөр</i> <i>(Жич: “ДБЭХС”ТӨХК-ийн горим ажиллагаанаас хамаарч хугацаа өөрчлөгдөж болно.)</i> |
| ГЕН 7.1 | Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш <i>[тоо]</i> хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана. |
| ГЕН 9.1 | Чанарын баталгаат хугацаа <i>[365]</i> хоног байна. |
| ГЕН 13.1 | Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн <i>[0,5%]</i> байна. ⁴ Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн <i>[10%]</i> байна. |
| ГЕН 17.1 | Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг <i>[огноо]</i> -ны дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг <i>[огноо]</i> -ны дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ <i>[мөнгөн дүн]</i> байна. |
| ГЕН 19.1 | Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын <i>[0%]</i> -иартооцно. |

³ Захиалгачтэндэрийнбаримтбичгийгтараахаасөмнөэрээнийтусгайнөхцөлийгбүрэнбөглөсөнбайна.
Захиалагчийнгаргаххуваарь, тайлантгэрээнийтусгайнөхцөлдхавсаргана.

⁴ Ажлыгхэсэгхэсэргүй тодотгосон ажлын хөтөлбөрийн хэмжээ*[мөнгөн дүн]* байна.

ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

ГҮЙЦЭТГЭГЧ

| | |
|-----------------|-----------------|
| (Тамга, тэмдэг) | (Тамга, тэмдэг) |
| (Гарын үсэг) | (Гарын үсэг) |
| (Албан тушаал) | (Албан тушаал) |

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны _____ сарын _____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж сууринуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: _____ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь _____ байршилтай _____ хүчин чадал бүхий _____ ам.метр талбай/_____ шоо метр эзлэхүүн/-тай, _____ суурь, _____ хана, _____ хүчилттай, _____ давхар _____ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж сууринуулах/-ын ажлыг _____ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, _____ туслах барилга /бусад ажил/-ын хамт _____ оны _____ дугаар сарын _____ -ны өдөр эхэлж, _____ оны _____ дугаар сарын _____ -ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3. Үнийн санал
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;

- 5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт;
- 5.7. Зураг;
- 5.8. Гүйцтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь :
- 5.9. Санхүүжилтийн хуваарь;
- 5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]